



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/22

Даланзадгад сум

Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам,  
эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын  
дээд хэмжээ тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны 2024 оны "Аргачлал батлах тухай" 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 540.4 сая төгрөгөөр тогтоосугай.
2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.
3. Энэхүү тушаалаар тогтоосон зардлын дээд хэмжээг олон нийтэд мэдээлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Т.Хонгорзул)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР



Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын  
26 -ны өдрийн 142 дугаар тушаалын хавсралт

АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛИЙН ТОЙРОГТ НЭГ НЭР ДЭВШИГЧЭС  
СОНГУУЛЬД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭ

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Зардлын дээд хэмжээ /сая төгрөгөөр/
1	Баяндалай сум	60.8
2	Баян-Овоо сум	59.6
3	Булган сум	62.8
4	Гурвантэс сум	69.6
5	Мандал-Овоо сум	59.5
6	Манлай сум	63.3
7	Ноён сум	56.8
8	Номгон сум	62.1
9	Сэврэй сум	60.2
10	Ханбогд сум	74.0
11	Ханхонгор сум	62.7
12	Хүрмэн сум	59.4
13	Цогт-Овоо сум	60.0
14	Цогтцэций сум	78.1
15	Даланзадгад 1 дүгээр баг	66.5
16	Даланзадгад 2 дугаар баг	58.3
17	Даланзадгад 3 дугаар баг	60.5
18	Даланзадгад 4 дүгээр баг	60.3
19	Даланзадгад 5 дугаар баг	58.3
20	Даланзадгад 6 дугаар баг	65.5
21	Даланзадгад 7 дугаар баг	57.8
22	Даланзадгад 8 дугаар баг	58.7
23	Даланзадгад 9 дүгээр баг	54.7
24	Даланзадгад 10 дугаар баг	54.8